

2020 жилийн тайлан

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, Санхүүгийн Зохицуулах Хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран тэргүүлэх 4 чиглэлээр буюу сургуулийн насанд, залуу үед, хөдөө орон нутгийн иргэд болон цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлж байна. Санхүүгийн боловсрол дээшилснээр дараах голлох үр дүнд хүрнэ:

Санхүүгийн боловсрол дээшилснээр дараах голлох үр дүнд хүрнэ:

- Иргэдийн санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ойлголт нэмэгдэж, илүү үр дүнтэй ашиглана;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно;
- Санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, чанаргүй зээлийн түвшин багасна;
- Хөрөнгийн зах зээл дэх оролцоо, хөрөнгө оруулалт өснө.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд;
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт;
- Хадгаламж;
- Зээл;
- Хөрөнгө оруулалт;
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт);
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх;
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголтууд;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар ойлголтууд.

2020 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн болно. Үүнд:

Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар

Монгол улсын засгийн газрын 2017 оны 299 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилго 6.2 “Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болгоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 98-р тогтоолын Зорилт 3.3 “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг сайжруулна” хэмээн тусгагдсаныг хэрэгжүүлж ажиллаа.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5-р зүйлийн 1.7-д “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж заасны дагуу Монголбанкнаас бусад байгууллагуудтай хамтран санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан хууль санаачлагч нарт уламжилсан ба УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, зохих саналуудыг тусган УИХ-ын чуулганд танилцуулахаар тогтлоо. Энэ хуулийн зорилт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн хэрэглэгчтэй харилцах, санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгох, нийлүүлэхэд тавигдах шаардлагыг тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зээлдэгчийн эрх болон санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, түүнтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, олон нийтэд санхүүгийн боловсрол олгох замаар санхүүгийн зах зээлийн зохистой хөгжил, хүртээмж, чадамжийг дээшлүүлэхэд оршино. Дээрх хуулийн төсөлд “санхүүгийн боловсрол ба хяналт” бүлэг орсон болно.

Зээлийн хүүг бууруулах стратеги

СТБЗ-ийн зөвлөмжөөр Монголбанкнаас “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-ийг хэрэгжүүлж байгаа ба уг стратегийн 11 дэх Зорилтод “Санхүүгийн байгууллага, тэдгээрийн хэрэглэгч болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх” заалт тусгагдаж, үүний дагуу ажлууд хийгдэж байна. Мөн энэхүү стратегийн үргэлжлэл болгож 2020 оны 8-р сарын 28-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” тогтоолыг баталсан. УИХ-ын 21 дугаар тогтоолоор батлагдсан уг стратегийн зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлд “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх” заалт тусгагдан, хэрэгжүүлж байна.

Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг сонгон судлахаар БСШУ-ны сайдын 2019 оны А/491 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалыг баталсан. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж ЕБС-ийн нийгмийн ухааны багш нар “Бизнес судлал” хичээлийг зааж байгаа ба Монголбанкнаас энэхүү ажилд дэмжин ажиллаж байна.
- Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор үндэсний хэмжээнд Монголбанк Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дэмжих хүрээнд тус судлагдахууныг заах түүх, нийгмийн ухааны 1870 багшийг чадавхжуулахад Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран ажиллалаа.

Залуучуудад санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 3 кредит бүхий “Хувь хүний санхүү” хичээлийг магадлан итгэмжлэгдсэн 13 их, дээд сургуульд орж байна.

- Цар тахлын улмаас халдвар хамгааллын дэглэмийг сахин танхимын болон цахим сургалтуудыг зохион байгуулж, нийт 1200 орчим оюутан, залуус хамрагдлаа.
- Монголбанк, БШУЯ-ны харъяа Насан түршийн боловсролын үндэсний төв, Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран 729 санхүүгийн сургагч багш нарыг өнгөрсөн хугацаанд бэлтгэсэн ба залуучуудад мэдлэг, мэдээлэл өгөх чиглэлээр ажиллав.
- Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох 24,000 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, “Мөнгөө хэрхэн удирдах вэ?”, “Зээл”, “Өрхийн төсөв”, “Хуримтлал ба хадгаламж”, “Үнийн түвшин”, “Валютын ханш” зэрэг сэдвээр гарын авлагыг түгээж ажиллав.
- Мөн Монголбанк Залууст санхүүгийн боловсрол олгох зорилтот үйл ажиллагааг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хэрэгжүүлэхээр санамж бичигт гарын үсэг зурлаа. Талуудын хамтын ажиллагааны үр дүнд залуусын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлснээр тэдний санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх, хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт хийх мэдлэг, чадварыг дэмжих шинэ боломжийг бий болгох юм. Санамж бичгийн хүрээнд хувь хүний санхүүгийн боловсрол олгох амьдрах ухааны хөтөлбөрийг хамтран боловсруулах, санхүүгийн сургагч багш нарыг бэлтгэх, олон талт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, санхүүгийн мэдлэг олгох гарын авлага, багшийн ном, сургалт явуулахад ашиглагдах материал, видео хичээл болон бусад цаг үеийн хэрэглэгдэхүүнийг боловсруулж, түгээх зэрэг ажлууд хийгдэнэ.

Цахим хуудсаар санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuuginbolovsrol.mn цахим хуудсыг тогтмол баяжуулан ажиллалаа.
- “Монголбанкны мэдээлэл”, “Монголын эмэгтэйчүүд” сар бүрийн товхимол, ЦЕГ-ын “Амрыг эрье” улирал тутмын товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллууллаа.
- “Санхүүгийн боловсрол” фейсбүүк пэйжийг тогтмол мэдээ, мэдээллээр ханган 6000 гаруй дагагчтай боллоо.
- МҮОНР-гийн “Санхүүгийн мод” нэвтрүүлгээр 29 дугаарыг шууд эфирээр болон фейсбүүкээр олон нийтэд түгээв. Мөн МҮОНР-ын дэргэдэх “Пи 3” радиотой хамтран “Энгийн эдийн засаг” нэвтрүүлгийг хамтран бэлтгэж, 18 дугаарыг санхүү, эдийн засгийн ойлголтыг энгийн, ойлгомжтой олгох чиглэлээр ажиллав.
- Иргэдийн эдийн засгийн мэдлэгт зориулж kon.mn цахим сайтад Эдийн засаг энгийнээр буланг нээж тогтмол мэдээллээр баяжуулж ажиллалаа.

Олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал

ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан

- Монголбанк, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын “Остпригнитц-Руппины Шпаркассэ” банктай хамтран “Монгол Улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлээд 3 жил болж байна. Энэхүү хугацаанд 7 модуль бүхий сургалтад арилжааны 11 банкны нийт 185 оролцогч, сургагч багш бэлтгэх хөтөлбөрт нийт 94 багш амжилттай хамрагдсан байна. Үүнээс энэ жил Улаанбаатар хотод 30 мэргэжилтэн амжилттай хамрагдав. Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, арилжааны 11 банк хамтран “Хуримтлуулах, хялбархан”

уриатайгаар 10 дугаар сарын 31-ний өдөр “Дэлхийн хуримтлалын өдөр”-ийг Улаанбаатар хотноо, Дархан-Уул аймагт, 10 дугаар сарын 22-ны өдөр Орхон аймагт, 10 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатар аймагт хийж, иргэдэд, хүүхэд багачуудад санхүүгийн мэдлэг олгох, хуримтлалыг хэвшил болгохыг дэмжсэн үйл ажиллагаануудыг өрнүүлээ.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк /EBRD/

Монголбанк, Европын сэргээн босголт хөгжлийн банк хамтран “Бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох стратеги” болон “Сургалтын модуль” бэлтгэж, боловсруулах ажлыг 2020 онд эхлүүллээ. Энэ ажлын хүрээнд сургагч багш нарыг бэлтгэх, БЖДҮ эрхлэгчдэд сургалтанд хамруулах, тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх өргөн хэмжээний арга хэмжээг хэрэгжүүлэх ба цаашлаад дэд хөтөлбөр болон батлагдах юм.

OECD/INFE Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ

ЭЗХАХБ-ын ЕвроАзийн өрсөлдөх чадварыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ЭЗХАХБ нь бичил, жижиг, дунд үйлдвэрүүдийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах талаар Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллан үр дүнгийн талаарх мониторинг хийсэн болно. Үүнд өнгөрсөн 3 жилд гаргасан ахиц дэвшлийг үнэлж, цаашид хэрэгжүүлэх зөвлөмжид: “.....хяналт шинжилгээний хүрээнд Монголбанкны санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх стратеги ба арга хэрэгслүүд боловсруулж хэрэгжүүлсэн байдал болон ЭЗХАХБ-ны олон улсын санхүүгийн боловсролын сүлжээнд элссэнийг” онцлов.

2019 жилийн тайлан

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, БСШУЯ /хуучин нэрээр/ хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран тэргүүлэх 4 чиглэлээр буюу сургуулийн насанд, залуу үед, хөдөө орон нутгийн иргэд болон цахим хуудас, мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлж байна.

Санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр дараах гол үр дүнгүүд гарна:

- Иргэдийн мэдлэг дээшилснээр санхүүгийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ.
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно.
- Санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх явдал нэмэгдэж, түүнд өртөх иргэдийн тоо буурна.
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна.
- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт
- Хадгаламж
- Зээл
- Хөрөнгө оруулалт
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт)
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголтууд
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар ойлголтууд

2019 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн болно. Үүнд:

Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар

Монгол улсын засгийн газрын 299 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн Зорилго 6.2 “Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болгоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 98-р тогтоолын Зорилт 3.3 “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг сайжруулна” хэмээн тусгагдав.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл

2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг өргөн барилаа. Энэ хуулийн зорилт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн хэрэглэгчтэй харилцах, санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгох, нийлүүлэхэд тавигдах шаардлагыг тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зээлдэгчийн эрх болон санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, түүнтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, олон нийтэд санхүүгийн боловсрол олгох замаар санхүүгийн зах зээлийн зохистой хөгжил, хүртээмж, чадамжийг дээшлүүлэхэд оршино. Дээрх хуулийн төсөлд “санхүүгийн боловсрол ба хяналт” бүлэг орсон болно.

“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” -ийн хэрэгжилт

Зорилт 11. Төрийн болон санхүүгийн байгууллагын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлд “Санхүүгийн байгууллага, тэдгээрийн хэрэглэгч болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх” ажил хийгдэж байна.

Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Монголбанк, МБХ, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан хамтран "Дэлхийн мөнгөний долоо хоног 2019" /Global Money week/ арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Үүнд: Нэгдсэн удирдамж гарган арилжааны банк, орон нутгийн бүх салбар, хэлтсүүд 3 дугаар сарын сүүлийн 7 долоо хоногийн турш өнгөрүүлж, эдийн засаг, мөнгө, санхүүгийн зуучлалын талаарх ойлголтын аймаг сумдын ЕБС, банкныханд сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 46 000 хүүхэд залуучуудад хүрэв. Мөн Монголбанкны эрдэнэсийн сангаар хүүхдүүд зочилж санхүүгийн мэдлэгийн сургалтад хамрагдав.
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид сонгон судлахаар санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” судлагдахууныг боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/491 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар батлав.
- БСШУСЯ-наас 2019-2020 оны хичээлийн шинэ жилийг угтаж, Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор үндэсний хэмжээнд 550 сургагч багшийг бэлтгэж цаашлаад бэлтгэгдсэн багш нар нь 21 аймаг, 9 дүүрэгт нийт 44000 багш, сургуулийн удирдлагыг сургалтад хамруулав. Нийт 22 судлагдахуун дотор санхүүгийн мэдлэг олгох, “Бизнес судлал” судлагдахуун багтаж буй бөгөөд Монголбанк Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор тус судлагдахууныг заах түүх, нийгмийн ухааны 1870 багшийг чадавхжуулахад Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран ажиллалаа.
- Банк Санхүүгийн Академитай хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд асрамжийн газрын 15-18 насны хүүхдүүдэд хувийн санхүүгээ удирдах, санхүүгийн суурь боловсрол олгоход зориулсан аян санаачлан эхлүүлэн 5 удаагийн ОНСБ-ын сургалт, 5 банкинд аялуулан нэгдсэн арга хэмжээ, хэлэлцүүлгийг Монголбанк болон Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран хийж, өнчин хүүхдүүдэд хуримтлал хадгаламж үүсгэх, орлого зардлаа бүртгэж

хөтлөх, мөнгө санхүүгээ хэрхэн зөв удирдах тухай ойлголтыг өгч эдийн засгийн зөв хүмүүжилтэй болгоход чиглэгдсэн, санхүүгийн боловсролын эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 100 хүүхдийг Монголбанкны Эрдэнэсийн сангаар зочлуулан сургалт зохион байгуулав.

- Монголбанк Хаан банкт хамтран санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийн хүрээнд #UnreadGrowthProgram-ын оролцогчдын дунд “ЕБС-ийн төгсөх ангийн хүүхдүүдэд санхүүгийн цогц мэдлэг олгох уралдаан” зарлаж, шилдэг багуудыг шалгарууллаа. Уралдаанд оролцсон 8 баг гурван 7 хоногийн хугацаанд 1,600 гаруй хүүхдэд санхүүгийн боловсролын тухай мэдлэг ойлголт өгч, мэргэжил сонголтоо хэрхэн хийх талаар мэдээлэл хүргэсэн байна.

Залуучуудад санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Монголбанкнаас Олон нийтийн санхүүгийн сүүр мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр болон “Банкны хөгжил – 95 жил” аяны хүрээнд “Хувь хүний санхүү” хичээлийг сонгон судалж буй 1-р курсийн оюутнуудын дунд “Хэн сайн санхүүч болох вэ?” сэдэвт АХА тэмцээнийг зохион байгууллаа. Уламжлал болон дөрөв дэх жилдээ зохион байгуулагдаж энэ удаагийн тэмцээнд Монгол Улсын их сургууль, Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Улаанбаатар-эрдэм их сургууль, Эдийн засгийн үндэсний дээд сургуулийн 400 гаруй оюутан оролцож, оюун ухаан, мэдлэг чадвараа сорилоо.
- “Банкны Хөгжил-95 жил” аяны хүрээнд “БАНКНЫ ӨДӨРЛӨГ”-ийг Сүхбаатарын талбайд 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Монголбанк, Монголын банкны холбоо, арилжааны 13 банк, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгт банкны салбар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах, санхүүгийн мэдлэг олгох чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан болно.
- ЦЕГ-ын албан хаагчдад болон БСШУСЯ-ны харъяа НТБҮТ-ийн мэргэжилтэнд санхүүгийн мэдлэг олгох сургалтыг үе шаттайгаар 8 удаа зохион байгуулав.
- “Банкны хөгжил – 95 жил”, “Хариуцлагатай харилцагч, хариуцлагатай банк” аяныг 1-6 дугаар сар, 10-12 дугаар саруудад олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох чиглэлээр амжилттай зохион байгуулав.

Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Монголбанк, БСШУСЯ-ны харъяа Насан түршийн боловсролын үндэсний төв, Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран Дорноговь, Говь-Сүмбэр, Өвөрхангай, Архангай, Завхан, Хөвсгөл аймгуудын Насан түршийн боловсролын төв, МСҮТ, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын багш нарыг "Санхүүгийн сургагч багш"-аар бэлтгэж нийтдээ 21 аймгийн 729 сургагч багштай боллоо.
- Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох 7500 ширхэг гарын авлагыг “Мөнгөө хэрхэн удирдах вэ?”, “Зээл”, “Өрхийн төсөв”, “Хуримтлал ба хадгаламж”, “Үнийн түвшин”, “Валютын ханш”-ийг орон нутгийн сургалтын үеэр түгээж ажиллав.

Цахим хуудсаар санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuugiinbolovsrol.mn цахим хуудсыг тогтмол баяжуулан ажиллалаа.
- “Монголбанкны мэдээлэл”, “Монголын эмэгтэйчүүд” сар бүрийн товхимол, ЦЕГ-ын “Амрыг эрье” улирал тутмын товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллууллаа.

- “Санхүүгийн боловсрол” фейсбүүк пэйжийг тогтмол мэдээ, мэдээллээр ханган 8500 дагагчтай боллоо.
- ҮОНР-гийн “Санхүүгийн мод” нэвтрүүлгээр 38 дугаарыг шууд эфирээр болон фейсбүүкээр олон нийтэд түгээв.
- Иргэдийн эдийн засгийн мэдлэгт зориулж Ikon.mn цахим сайтад Эдийн засаг энгийнээр буланг нээж тогтмол мэдээллээр баяжуулж ажиллалаа.

Харилцагч байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал:

- Монгол Улс Олон улсын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролын байгууллага /Child&Youth Finance International/-ын “Шилдэг түншлэл-2019” шагнал хүртэв. Дэлхий нийтийн санхүүгийн хүртээмжийн шагнал нь үндэсний хэмжээнд болон бүс нутаг, олон улсын түвшинд хүүхэд, залуусын санхүү, нийгэм, насан туршийн боловсролд хувь нэмрээ оруулж байгаа улсуудыг онцолж, шагнал олгодог. Энэ удаа нийт 170 улс өрсөлдсөн бөгөөд Шилдэг улс категорин Шилдэг түншлэл төрөлд Монгол Улс нь Ангол, Аргентин, Колумби, Морокко, Португали гэсэн улсуудтай тунаж үлдсэнээр эцсийн шатанд тэргүүлэв.
- Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, ХБНГУ-ын Остпригнитц-Руппины Шпаркассэ банк, арилжааны 13 банк хамтран “Хариуцлагатай харилцагч, хариуцлагатай банк” аяны хүрээнд “Хэмнэе, хуримтлуулъя” уриатайгаар 10 дугаар сарын 31-ний өдөр “Дэлхийн хуримтлалын өдөр”-ийг Улаанбаатар хотноо, Монголын хүүхдийн ордонд тэмдэглэлээ. Нээлттэй арга хэмжээний үеэр банкууд хүүхэд багачуудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, газар дээр нь хуримтлалын данс нээж ажилласан. Монголбанк болон ХБНГУ-ын Шпаркассэ банкны сангийн зүгээс хуримтлал үүсгэхийн ач тус давуу талыг танилцуулсан гарын авлага, ном товхимлуудаа хүүхэд багачуудад танилцууллаа. 2019 онд “Дэлхийн Хуримтлалын Өдөр”-ийн үйл ажиллагаа нь 11 дүгээр сарын 6-нд Дархан хотод, 11 дүгээр сарын 8-ны өдөр Эрдэнэт хотод тус тус зохион байгуулсан нь онцлог болов.

Олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал

OECD/INFE Эдийн засгийн хамтын ажилгааны хөгжлийн байгууллагын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ

2019 онд ЭЗХАХБ-ын ЕвроАзийн өрсөлдөх чадварыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ЭЗХАХБ нь бичил, жижиг, дунд үйлдвэрүүдийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах талаар Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллан үр дүнгийн талаарх мониторинг хийсэн болно. Үүнд өнгөрсөн 3 жилд гаргасан ахиц дэвшлийг үнэлж, цаашид хэрэгжүүлэх зөвлөмжид: “.....хяналт шинжилгээний хүрээнд Монголбанкны санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх стратеги ба арга хэрэгслүүд боловсруулж хэрэгжүүлсэн байдал болон ЭЗХАХБ-ны олон улсын санхүүгийн боловсролын сүлжээнд элссэнийг” онцлов.

ЭЗХАХБ-ын ээлжит техникийн зөвлөлийн хурлуудад оролцож Монгол улсын санхүүгийн боловсролын бодлогын талаарх мэдээлэл тогтмол өгсөний үр дүнд Монгол Улсыг төлөөлж Монголбанкнаас Камбож Улсад болсон Олон Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын “Санхүүгийн оролцоог дэмжихэд санхүүгийн боловсрол ба хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүрэг” нэртэй хуралд оролцож, Монгол Улсын санхүүгийн боловсролын стратегийг танилцуулав.

ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан

Монголбанк, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын “Остпригнитц-Руппины Шпаркассэ” банктэй хамтран “Монгол Улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлээд 3 жил болж байна.

Энэхүү хугацаанд 7 модуль бүхий сургалтад арилжааны 11 банкны нийт 155 оролцогч, сургагч багш бэлтгэх хөтөлбөрт нийт 94 багш амжилттай хамрагдсан байна. Үүнээс энэ жил Улаанбаатар, Дархан-Уул аймгийн нийт 73 мэргэжилтэн амжилттай төгсөж, батламжаа гардаж авлаа.

Монгол Улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт нь өнгөрсөн жилүүдэд Улаанбаатар хотод явагдаж байсан бол энэ жил хүрээгээ тэлэн Дархан-Уул аймагт мөн зохион байгуулагдсанаараа онцлог байв.

Дэлхийн банк /ДБ/

Дэлхийн банкнаас орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох 11 модуль бүхий багшийн ном, аудио хичээл болон суралцагсдын гарын авлагын төслийг боловсрууллаа. Дэлхийн Банк, Монголбанк, Насан түршийн боловсролын үндэсний төв хамтран 2019 оны 6 сарын 4-6-ны өдрүүдэд түршилтын сургалтыг зохион байгуулав. Сургалтаар шинэ загварыг түршиж, багш нарын саналыг тусган хичээлийн агуулгыг илүү энгийн, ойлгомжтой болгосноор хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорьж байна.

2018 жилийн тайлан

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, БСШУЯ (хуучин нэрээр) хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран тэргүүлэх 4 чиглэлээр буюу сургуулийн насанд, залуу үед, хөдөө орон нутгийн иргэд болон цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлэв.

Санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр дараах гол үр дүнгүүд гарна:

- Иргэдийн мэдлэг дээшилснээр санхүүгийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ.
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно.
- Санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх явдал нэмэгдэж, түүнд өртөх иргэдийн тоо буурна.
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна.
- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт
- Хадгаламж
- Зээл
- Хөрөнгө оруулалт
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт)
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголтууд
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаарх ойлголт зэрэг сэдэв багтана.

2018 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийв. Үүнд:

Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар

Монгол улсын засгийн газрын 299 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” –ийн Зорилго 6.2 “Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болгоно” заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

2018 оны 11-р сарын 15-ны өдрийн УИХ-ын “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 84-р тогтоолын Зорилт 3.2 “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ” хэмээн тусгагдав.

Төв банк (Монголбанкны)-ны тухай хууль

2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулснаар Монголбанкны үйл ажиллагааны чиглэлд “Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” заалт батлагдсан болно.

“Зээлийн хүүг бүүруулах стратеги 2018-2023”

Зорилт 11. Төрийн болон санхүүгийн байгууллагын засаглалыг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлд “Санхүүгийн байгууллага, тэдгээрийн хэрэглэгч болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх” ажил хийгдэж байна.

“Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”

2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн Монголбанкны ерөнхийлөгчийн А/203 тушаалаар батлагдсан тус журмын “Мэдээллийн ил тод байдал”-хэсэгт санхүүгийн харилцагчийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэл багтсан болно.

Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Банк Санхүүгийн Академийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монголбанк болон Хадгаламжийн Даатгалын Корпорациатай хамтран “Өнөр бүл” хүүхдийн төв болон “Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн төв”-ийн 15-18 насны хүүхдүүдэд 5 сард хувийн санхүүгээ удирдах, санхүүгийн суурь боловсрол олгоход зориулсан хөтөлбөрөөр дэмжин оролцлоо. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлэгт санхүүгийн суурь ойлголтуудыг шат дараатайгаар олгож, бие даан амьдрахад нь зайлшгүй шаардагдах санхүүгийн мэдлэгт суралцуулах замаар ирээдүйгээ өөрсдөө бүтээх чадварт сургах нь энэхүү аяны зорилго юм.

Банкуудын зүгээс дараах 5 сэдвээр мэдлэг мэдээлэл өгч, банкны үйл ажиллагаатай танилцах аяллыг хийхийн зэрэгцээ тухайн сонгосон сэдвээр мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, ирээдүйн харилцагчдаа бэлтгэхэд хамтран ажиллалаа.

Аяны хүрээнд хийсэн сургалтын сэдвүүд нь:

- Орлого ба зардал /Хас банк/
 - Хуримтлал ба хадгаламж /Ариг банк/
 - Өр ба зээл, хүүгийн тухай ойлголт /Худалдаа Хөгжлийн Банк/
 - Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, тэдгээрийн тухай ойлголт /Хаан банк/
 - Эрсдэл ба даатгал /Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк/
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид сонгон судлахаар санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 9-ний өдрийн А/453 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар батлав.
- 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн ухааны 30 арга зүйч нарт 12 ангид үзэх “Бизнес судлал” хичээлийн талаарх сургалтыг БСШУСЯ-аас зохион байгуулав.

- Ерөнхий боловсролын сургуулийн “Бизнес судлал” сонгон судлах хичээлийн 11,12 дугаар ангийн багшийн ном боловсруулан хэвлэв.
- Хүүхдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох “Анар, Ану 2”-ын 3 төрлийн цуврал комик ном 9000 хувь хэвлэгдэж ерөнхий боловсролын сургууль, орон нутаг болон санхүүгийн боловсрол олгох арга хэмжээнүүдэд түгээн ажиллав.
- Олон улсын Мөнгөний долоо хоног буюу (Global Money week)-тэй холбогдуулан “Дэлхийн мөнгөний долоо хоног-2018”-д хүүхэд залууст мөнгөний талаарх ойлголт, мэдлэгийг өгөх цуврал өдөрлөгүүдийг зохион байгуулж Монголбанк, Монголын Банкны Холбоо, арилжааны банкууд хамтран ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 700 сургачдад “Мөнгөний асуудал бол чухал” сэдвээр хичээл орж Төв банкны эрдэнэсийн сангаар зочлууллаа.
- Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын “Шпаркассе” сан болон арилжааны 10 банк хамтран Дэлхийн хуримтлалын өдрийг тохиолдуулан “Хуримтлалын аян”-ыг 10 дугаар сарын 22-ноос эхлүүлэн Дэлхийн хуримтлалын өдрийн арга хэмжээг 31-нд Улаанбаатар хотод, 11 дүгээр сарын 2-ний өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулсан бөгөөд энэ хүрээнд банкууд хүүхэд багачуудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, газар дээр нь хуримтлалын данс нээж ажилласан юм. Түүнчлэн Монголбанк болон ХБНГУ-ын “Шпаркассе” сангийн зүгээс хуримтлал үүсгэхийн ач тус давуу талыг танилцуулсан гарын авлага, ном товхимлуудаа хүүхэд багачуудад танилцууллаа. Мөн энэ үеэр Хадгаламжийн даатгалын корпорацийн зүгээс хүүхэд багачуудын дунд асуулт, хариултын тэмцээн зохион байгуулж, зөв хариулсан хүүхдүүдэд 50 мянган төгрөгийн “Хадгаламжийн сертификат” гардуулж ажилласан. Мөн энэ жилийн “Дэлхийн хуримтлалын өдөр-2018” аянд нийт 10 банк идэвхтэй оролцож, хүүхэд залуусын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, хуримтлалын ач тусыг тайлбарлан таниулахад анхаарч ажилласан. Аянд идэвхтэй оролцсон шилдэг 3 банкаар Тээвэр Хөгжлийн Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Голомт банкны хамт олон шалгарлаа.

Залууст санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох “Хувь хүний санхүү” сэдэвт (1 кредит) хичээлийг бүх их дээд сургуулийн хөтөлбөрт мэргэжил харгалзахгүй тусгуулах зорилгоор боловсруулсан бөгөөд хөтөлбөр хэрэгжсэнээс хойш тус хичээлийг 13 их дээд сургууль сургалтын хөтөлбөрт оруулснаас 2018 онд Эдийн засгийн Үндэсний Дээд Сургууль, Хууль сахиулах их сургууль, Дорнод их сургууль сургалтын хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байна.
- ХНХЯ-тай хамтран политехник коллеж, мэргэжлийн боловсрол-сургалтын төвийн хөтөлбөрт “Хувь хүний санхүүгийн мэдлэг”, “Хувь хүний санхүү, бизнес, аж ахуй эрхлэлт”, “Эдийн засгийн онол”-ийн хичээлийг заах 21 аймгийн 45, Улаанбаатар хотын 48 мэргэжлийн багш нар “Сургагч багш” бэлтгэх сургалтад хамрагдаж “Гэрчилгээ” гардан авлаа.
- Монголбанк болон Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт нь “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд үндэсний хэмжээнд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг нэмэгдүүлэх, жижиг дунд аж ахуйн нэгж, бичил бизнес эрхлэгчдийн бүртгэл, тайлагналын чанарыг сайжруулах, салбарын мэргэжилтний чадварыг тасралтгүй хөгжүүлэх, мэргэшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд хамтран оролцох, хамтын ажиллагааг нэгтгэн чиглүүлэх зорилгоор "Хамтын ажиллагааны санамж бичиг" байгууллаа.

Орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох 9 төрлийн гарын авлагыг дараах сэдвүүдээр сажруулалт хийн 19 000 хувийг хэвлүүлэв: төв банк юу хийдэг вэ? мөнгөө хэрхэн удирдах вэ? өрхийн төсөв, хуримтлал ба хадгаламж, зээл, үний түвшин, валютын ханш, таны санхүүгийн мэдлэгт, өрхийн төсвийн дэвтэр зэрэг болно.
- Монголбанкны орон нутгийн салбаруудаараа дамжуулан орон нутгийн иргэд, банк санхүүгийн салбарын ажилтнууд болон сурагчдад санхүүгийн боловсролыг түгээн ажиллаж байна.
- Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран Насан туршийн боловсролын үндэсний төвийн орон нутгийн төвүүдтэй хамтран Говь-Алтай, Баянхонгор, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Завхан, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Орхон, Улаанбаатар хотын дүүргийн нийт 265 багшийг “Сургагч Багш”-ийн сургалтад хамруулан иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалт тогтмол зохион байгуулан 22,140 иргэнд хүрч ажиллав.

Цахим хуудас, олон нийтийн хэрэгслээр санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuuginbolovsrol.mn цахим хуудсыг тогтмол баяжуулан ажиллалаа.
- Иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ удирдах, хяналттай төсөв зохиох, “Төсөвчин” аппликейшн IOS, android үйлдийн системд нэвтэрч хэрэглэгчдэд түгээн ажиллав.
- “Монголбанкны мэдээлэл” сар бүрийн товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллуулж байна.
- Санхүүгийн боловсрол олгох 3 төрлийн богино хэмжээний видео боловсруулж олон нийтэд түгээв. Үүнд: валютын ханш, зээлийн мэдээллийн сан, тэтгэврийн зээл.
- “Санхүүгийн боловсрол” фэйсбүк пэйжийг тогтмол мэдээ, мэдээллээр ханган ажиллалаа.

“Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” аяны хүрээнд:

2018 оны 1 дүгээр сарын 02-ноос 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх 5 сарын хугацаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн санаачилгаар орон даяар “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян”-ыг зохион байгууллаа.

Аяны хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монголын Ипотекийн Корпораци, Монголын банкны холбоо болон арилжааны нийт банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Бичил санхүүгийн хөгжлийн сан, Монголбанкны орон нутаг дахь хэлтэс салбар зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд хамтран оролцлоо.

Энэхүү аянаараа бид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан авч буй хувь хүн, бичил аж ахуйн нэгж, ирээдүйн санхүүгийн хэрэглэгчид рүү чиглэсэн суурь мэдлэг олгох, эрх үүрэг, хариуцлагыг ухамсарлуулах, ингэснээр гарч болох санхүүгийн олон талт эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах чадвар суулгахын зэрэгцээ нөгөө талаар, СҮҮ-ийг санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар санхүүгийн хэрэглэгч буюу иргэд-харилцагчдад хүртэж болох ашиг, үүсэж болох эрсдэл, санхүүгийн бусад нөхцөлийг үнэн зөв, ойлгомжтой тайлбарлах, сонголт хийх боломж олгох зэрэг үйл ажиллагааг хэвшүүлэхийг зорьж ажиллав.

Аяны хүрээнд хийгдэх ажлын 5 сарын дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөөг гаргаж, сар тус бүрт хийгдсэн үйл ажиллагааг 5 сэдвийн доор удирдан зохион байгуулж ажиллав. Үүнд:

- СҮҮ-ийн Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл өгөх аргачлал,
- Санхүүгийн хэрэглэгчийн хувийн мэдээлэл, нууцлалын аюулгүй байдал, түүний хамгаалалт;
- Санхүүгийн хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх,
- Төлбөрийн карт, түүний зохистой хэрэглээ, аюулгүй байдал,
- Орон сууцны ипотекийн зээл, зээлийн мэдээллийн сан гэсэн 5 ерөнхий сэдвийн хүрээнд танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг нийгмийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж, ТВ, радиогийн ярилцлага, нэвтрүүлэг, хэлэлцүүлэгт оролцож, сургалт, уулзалт, өдөрлөг хийх хэлбэрээр аяныг олон нийтэд хүртээмжтэй хүргэхийг зорьсны үр дүнд:

- "Сайн засаглал" сэтгүүлийн нэг улирлын дугаарыг "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тогтолцооны өнөөгийн байдал, БСХС–тай хамтран Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нь ямар ач холбогдолтой вэ?" сэдвийн хүрээнд гаргаж, иргэд, олон нийтэд зориулсан "Санхүүгийн хэрэглэгч танаа" 10,000 ширхэг гарын авлага, 3000 постер, 5000 ширхэг нугалбар болон бусад холбогдох хэвлэмэл материалуудыг давхардсан тоогоор 18000 хэвлүүлж, Улаанбаатар хотын 14 банкны төв аппарат, Орон нутагт дахь төр захиргааны байгууллагууд болон Монгол Улсын 21 аймаг дахь банкны 119 салбар, сүмын төв, алслагдсан сууринд байрлах 852 тооцооны төвөөр дамжуулан нийт 17000 иргэд, аж ахуйн нэгжид хүргэж ажилласан байна.

- БСХС, МИК болон Банкуудтай хамтран аяны хүрээнд зохион байгуулсан нийт 115 сургалт, семинар, уулзалтыг их, дээд сургуулийн оюутнууд, сургагч багш нар, сэтгүүлчид, төрийн албан хаагчид, хувиараа бизнес эрхлэгчид гэсэн тус тусын ЗОРИЛТОТ бүлэг рүү чиглүүлж ажилласны үр дүнд уг үйл ажиллагаанд давхардсан тоогоор Улаанбаатар хотын хэмжээнд нийт 45000 иргэн, аж ахуйн нэгж, аймгийн төвийн болон сумдын хэмжээнд нийт давхардсан тоогоор 59600 иргэд хамрагдсан байна. • Аяны хүрээнд мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор танин мэдэхүйн мэдээ, мэдээллийг нийгмийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж ажиллалаа. Цахим, сошиал орчин болоод нийт 121 удаагийн ТВ, радиогийн ярилцлага, нэвтрүүлэг, хэлэлцүүлэгт оролцож ажилласан байна. Банкууд өөр, өөрсдийн цахим хуудаснаа Мэдээлэл, Аюулгүй байдлын зөвлөмж цэсийг шинээр байршуулж, мэдээ мэдээлэл, танилцуулга видео шторк, зөвлөмжүүдийг тогтмол байршуулж, тэдгээрийг өөрсдийн харилцагчдад хүргэсэн үзүүлэлтийг харуулбал 1,500,000 хүрсэн байна.

- Аяны хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нийт 650,000 харилцагчийн гомдол, санал, хүсэлтэд зөвлөгөө өгч шийдвэрлэж ажиллалаа. Аяны хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар нэг удаагийн чанаргүй зээлийн түүхтэй 41000 гаруй иргэний зээлийн мэдээллийг лавлагаанд тусгахгүй байхаар шийдвэрлэсэн.

- Аян хэрэгжүүлсэн нийт 5 сарын хугацаанд "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах" хуулийн төслийн тандан судалгааг орон нутаг даяар давхар гүйцэтгэж, нийт 4000 иргэнийг судалгаанд хамруулсан.

- 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр буюу "Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр"-ийг ШӨХТГ, СЗХ, ХДК –тай хамтран “Цахим орчин дахь санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” сэдвийн доор нээлттэй хаалганы өдөрлөгийг ОРОН ДАЯАР зохион байгуулж өнгөрүүлснээрээ онцлог болж чадсан.
- Аяны хүрээнд банкууд өөрсдийн нэгдсэн санаачилгаар “Банкны салбарт хэрэглэгчийг хамгаалах нэгдсэн стандарт”- ыг боловсруулж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөхөөр боллоо.

Харилцагч байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал:

Дэлхийн банк

Дэлхийн банкны техникийн туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн эхний шатны мониторинг хийх зөвлөмжийг олон улсын экспертүүдийн баг ажиллан Монголбанкинд хүлээлгэн өгөв.

Германы Хадгаламжийн банкны ОУ-ын хамтын ажиллагааны сан

Монголбанк, ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын сан, Монголын банкны холбоотой хамтран “Монгол улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийн эхний шат дуусан Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын “Шпаркассе” банкны сан, ХБНГУ-ын “Остпригнитц-Руппины Шпаркассе” банк хооронд “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 3 жилийн хугацаатай байгууллаа.

Тус санамж бичигт оролцогч талууд хамтран:

- Монгол Улсын банк, санхүүгийн салбарын хөгжлийг банкны мэргэжилтний онол практик хосолсон сургалт, хүүхэд залуусын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрөөр дамжуулан эрчимжүүлэх,
- Банкны мэргэжилтний онол практик хосолсон сургалтын чанарыг тогтвортой байлгах;
- Төсөлд идэвхтэй оролцож буй банкуудын мэргэжилтнүүд болон удирдах албан тушаалтнуудад зориулан хэрэгцээт сэдвийн дагуу тусгайлсан семинарыг зохион байгуулах,
- “Дэлхийн хуримтлалын өдөр”-ийн аяныг үргэлжлүүлж, Монголбанк болон арилжааны банкуудтай хамтран жил бүр хамрах хүрээг тэлэх;
- “Шпаркассе” банкны сан нь өөрсдийн санхүүгийн нэгдлийн түршлагаас хуваалцах, эдгээр үндсэн 5 чиглэлийн ажлыг хэрэгжүүлнэ.
- Төслийн хүрээнд 2018 онд хийсэн ажил:
- Төслийн хүрээнд нийт 26 мастер сургагч багш анхан болон ахисан шатны сургалтууд зохион байгууллаа.
- Онол, практик хослуулсан сургалтыг 12 арилжааны банкнаас бүрдсэн нийт 41 оролцогчийг 7 модуль хичээлээр амжилттай бэлтгэв.
- Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын “Шпаркассе” сан болон арилжааны 10 банк хамтран “Дэлхийн хуримтлалын өдөр-2018” аяныг 10 дугаар сард хүүхэд залуусын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, хуримтлалын ач тусыг тайлбарлан таниулахад анхаарч амжилттай зохион байгуулав.

“Ази бүсийн Санхүүгийн боловсролын чуулга уулзалт”

Ази бүсийн Санхүүгийн боловсролын чуулга уулзалт нь жил бүр зохион байгуулагддаг чухал арга хэмжээ бөгөөд Aflatoun international олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, Ази тивийн улс орнуудын санхүү, нийгмийн боловсролыг дэмжих үйл ажиллагаа болон шинээр нэвтэрч буй туршлагын талаар хэлэлцэж, хуваалцдаг уулзалт болон хэвшжээ.

Энэ удаагийн чуулга уулзалтыг БНХАУ-ын “Be Better” олон улсын байгууллагаас зохион байгуулсан ба 2018 оны 11-р сарын 11-нээс 16-ны өдрийг сонгосон нь 4 дэх удаагаа болж байгаа БНХАУ-ын Боловсролын Инновацийн Экспотой давхцуулж, түүний хүрээнд хийх зорилготой байсан аж. Өөрөөр хэлбэл энэхүү чуулга уулзалт нь илүү том арга хэмжээний нэг хэсэг болсноороо онцлог юм. БНХАУ-ын Боловсролын Инновацийн Экспод 187 боловсролын их сургууль, коллеж болон нийт 50,000 орчим зочин оролцсон байна.

Ази бүсийн Санхүүгийн боловсролын чуулга уулзалтад Энэтхэг, Бангладеш, Филиппин, Шри Ланк, Пакистан, Индонез, Малайз, БНХАУ зэрэг Азийн 15 орноос санхүүгийн боловсролын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Боловсролын яамд болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцсон болно.

Монголбанкны хувьд Үндэсний хөтөлбөрийг тэргүүлэн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд тус арга хэмжээнд оролцох нь зайлшгүй шаардлагатай байсан бөгөөд олон улсын хэмжээнд хөтөлбөрийн чиглэл, үйл ажиллагааг амжилттай танилцуулав.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ Монголбанк нь ЭЗХАХБ/СБОУС-ний бүрэн эрхт гишүүн бөгөөд 2018 оны 10 дугаар сард ОХУ-ын Москва хотно зохион байгуулагдсан техникийн хорооны 10-р хурал, ЭЗХАХБ-ОХУ-ын Симпозиум: "Дэлхий дахины санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх: хэрэгжилт, шинэчлэл"- д тус тус оролцов. Техникийн зөвлөлийн хурал болон Симпозиум нь санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд дэлхий нийтийн дэвшилтийг бий болгохын тулд хэрэгжүүлэх шинэлэг арга барилд анхаарлаа төвлөрүүлэх чиглэлээр зохион байгуулав. Энэ нь санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн боловсрол олгох, залуучууд, шилжин суурьшигчид гэх мэт эмзэг бүлгийнхэнд санхүүгийн боловсрол олгож, санхүүгийн шийдвэр гаргах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах арга замыг тодорхойлох, зээлийн шийдвэр, үр дүнг сайжруулахад чиглэсэн чиг хандлагыг хэлэлцэв. 50 гаруй орны 200 гаруй мэргэжилтэн оролцсон бөгөөд засгийн газар, төв банк, санхүүгийн институт, ашгийн бус байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн, хувийн болон иргэний салбарын төлөөлөгчид оролцсон болно.

2017 жилийн тайлан

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь оролцогч талуудын хамтын ажиллагааны тэнцвэртэй байдлыг хангаж, авч буй арга хэмжээ, үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэн шаардлагатай арга хэмжээнд төвлөрөх боломжийг олгох зэрэг давуу талыг бий болгодог. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилгыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих боломжтой болно.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУЯ-ны хамтарсан тушаалаар баталсан.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Сургуулийн насныханд санхүүгийн мэдлэг олгох;
- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
- Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох.
- Санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр дараах гол гол үр дүн гарна:
- Иргэдийн мэдлэг дээшилснээр санхүүгийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ.
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно.
- Санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлэх явдал нэмэгдэж, түүнд өртөх иргэдийн тоо буурна.
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна.
- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаарх суурь ойлголтууд
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт
- Хадгаламж
- Зээл
- Хөрөнгө оруулалт
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт)
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх
- Нийгмийн даатгал болон татварын талаарх ойлголтууд
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаарх ойлголтууд

2017 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийсэн. Үүнд:

Монгол Улсын Засгийн газар

Монгол улсын засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” –ийн Зорилго 6.2 “Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болгоно” заалтыг хэрэгжүүлж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

2017 оны 11-р сарын 16-ны өдрийн УИХ-ын 70-р тогтоолоор батлагдсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын 3.1 “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг” үргэлжлүүлэх хэрэгжүүлнэ” – заалт оруулав.

Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид сонгон судлахаар санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн А/61 тоот “Ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг батлах тухай” тушаалаар батлав.
- “Бизнес судлал” хичээлийг улсын хэмжээнд нийт 84 сургагч багшийг бэлтгэв.
- Ерөнхий боловсролын сургуулийн “Бизнес судлал” сонгон судлах хичээлийн 10 дугаар ангийн сурах бичиг, багшийн ном, 11 дүгээр ангийн сурах бичиг боловсруулав.
- Хүүхдүүдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох “Анар, Ану 2: Мөнгөний мангас” цуврал комик номыг шинээр боловсруулан хэвлүүлж ерөнхий боловсролын сургууль, орон нутаг болон санхүүгийн боловсрол олгох арга хэмжээнүүдэд түгээн ажиллав.
- Олон улсын Мөнгөний долоо хоног буюу /Global Money week/-тэй холбогдуулан Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар; Монголбанк; Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам; Монголын банкны холбоо; Хадгаламжийн даатгалын корпораци; “Эрдэм мэдлэг түгээх төв” ТББ-тэй хамтарсан “Суралц - Хуримтлуул - Өсгө” уриан дор Монгол улсын бүх ЕБС-ийн бага, суурь ангийн сурагчид, 10-р ангийн сурагч болон багш нарын дунд уран бүтээл, эссе бичлэгийн уралдааныг зохион байгуулав.
- Монгол улсын түүх соёлыг агуулсан “Хуримтлалын бэлгэ тэмдэг”-тэй болов. Тус бэлгэ тэмдгийг хүүхдүүдэд таниулах зорилгоор Дэлхийн хуримтлалын өдрийн хүрээнд дүүрэг тус бүрээс ерөнхий боловсролын сургуулиудын 4-5 дугаар ангийн нийт 900 гаруй сурагчид санхүүгийн боловсрол, хуримтлалын ач холбогдлын талаар таниулах сургалт зохион байгуулав.

Залууст санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох “Хувь хүний санхүү” сэдэвт (1 кредит) хичээлийг бүх их дээд сургуулийн хөтөлбөрт мэргэжил харгалзахгүй тусгуулах зорилгоор сурах бичиг, дасгал ажлын номыг боловсруулан хэвлэв. Тус хичээлийг МУИС, ХААИС, СЭЗИС, Этүгэн их сургууль, олон улсын Улаанбаатар хотын их сургууль, Улаанбаатар эрдэм их сургууль, Дорнод их сургууль, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн дэргэдэх Ш.Отгонбилэгийн нэрэмжит техникийн сургууль, Олон улсын эдийн засаг, бизнесийн дээд сургууль зэрэг сургуульд 2017 оны сургалтын хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байна.
- Хувь хүний санхүү хичээлийг заах 48 их дээд сургуулийн багш нарыг “Сургагч Багш”- ийн сургалтанд хамруулан сертификат олгов.

- ХНХЯ-тай хамтран мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын сургалтын агуулгад нэмэлтээр “Хувь хүний санхүүгийн мэдлэг олгох” хичээлийг 2017 оны 9 сараас эхлэн орохоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 8 сард А/138 тушаал баталсан.
- Монголбанк болон Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “ХЭН САЙН САНХҮҮЧ БОЛОХ ВЭ?” сэдэвт АХА тэмцээнийг МУИС, СЭЗИС зэрэг их дээд сургуулиудын оюутнуудын дунд санхүүгийн мэдлэгийг түгээх зорилгоор уламжлал болгон 2 жил дарааллан зохион байгуулав.
- Жил бүрийн 6 дугаар сарын 2-ны өдрөөр банк санхүүгийн салбарын мэргэжилтнүүдээс гадна судлаач, багш эрдэмтэд болон бусад оролцогч талууд хамтдаа иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэхэд дуу хоолойгоо нэгтгэн, тэдний санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, улмаар санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгахад тодорхой хувь нэмрээ оруулахаар сайн туршлагаа хуваалцах, олон талт мэдлэгээ солилцох хэлэлцүүлгийг 3 дахь жилдээ өргөн хүрээнд зохион байгууллаа.

Орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох 13 төрлийн гарын авлагыг дараах сэдвүүдээр боловсруулав: төв банк юу хийдэг вэ? мөнгөө хэрхэн удирдах вэ? өрхийн төсөв болон санхүүгийн төлөвлөлт, хуримтлал ба хадгаламж, зээл, хөрөнгө оруулалт, даатгал, тэтгэвэр, нийгмийн даатгал болон татвар таны амьдралд, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь, бүтээгдэхүүний үнийн өсөлт ба валютын ханш, хөрөнгө оруулалт, мөнгө өсгөх арга, даатгал.
- Монголбанк орон нутгийн салбаруудаараа дамжуулан орон нутгийн иргэд, банк санхүүгийн салбарын ажилтнууд болон сурагчдад санхүүгийн боловсролыг түгээн ажиллаж байна.
- Монголбанк 2017 оныг орон нутгийн жилээр онцлон, өөрийн 17 салбарт сар бүр орон нутгийн иргэд, банк санхүүгийн салбарын ажилтнууд болон сурагчдад санхүүгийн мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулж гарын авлагаар хангаж ажиллав.
- БСШУСЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран Насан туршийн боловсролын үндэсний төвийн орон нутгийн, Улаанбаатар хотын дүүргийн нийт 198 багшийг “Сургагч Багш”-ийн сургалтанд хамруулан сертификат олгож, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалт тогтмол зохион байгуулан ажиллав.
- Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд Монголбанк, Бичил Санхүүгийн хөгжлийн сан, БСШУС-ын яамны харьяа Насан туршийн үндэсний боловсролын төв хамтран Орон нутгийн иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг нэмэгдүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд хамтран оролцох зорилгоор ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ зурав.

Цахим хуудас, олон нийтийн хэрэгслээр санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuugiiinbolovsrol.mn цахим хуудсыг олон улсын туршлага, Дэлхийн банкны техникийн туслалцааны хүрээнд боловсруулан олон нийтэд түгээж байна.

- Иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ удирдах, хяналттай төсөв зохиох, “Төсөвчин” аппликейшн IOS, android үйлдлийн системд нэвтэрч хэрэглэгчдэд хүртээл болов.
- “Монголбанкны мэдээлэл” сар бүрийн товхимолд санхүүгийн боловсрол олгох тогтмол буланг нээлээ.
- Санхүүгийн боловсрол олгох 2 минутын видео 9 шторк боловсруулж, олон нийтэд түгээв.

“Санхүүгийн боловсрол” аяны хүрээнд:

- “Санхүүгийн боловсрол” аян нь үндэсний хэмжээнд хэрэгжиж буй “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн ач холбогдол, хэрэгжилтийг олон нийтэд сурталчлах, хөтөлбөрийн үр дүн, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор 3 сарын хугацаатай аянг улсын хэмжээнд зохион байгууллаа. Аяны хүрээнд тэргүүлэх 4 чиглэл тус бүрээр олон нийтийг хамарсан ажлууд зохион байгуулж ажиллав.
- Монгол улс “Дэлхийн хуримтлалын өдөр”-ийг 2017 оны 10 дугаар сарын 31-ний өдөр ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын хамтын ажиллагааны сан, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо болон банк санхүүгийн байгууллагууд хамтран зохион байгуулав. Энэ үеэр банкууд хүүхдэд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, хүүхдүүдэд хуримтлалын хадгаламж нээж өгөв. Түүнчлэн 7-17 насны хүүхдүүдийн дунд “Би мөнгөө юунд зориулан хуримтлуулах вэ? ” сэдэвтэй хоёр долоо хоногийн хугацаатай уран зургийн уралдаан зарласан бөгөөд Улаанбаатар хот, хөдөө орон нутгаас 1150 бүтээл ирсэн. Арга хэмжээний үеэр уралдааны ялагчид шагнал гардууллаа. Мөн “Дэлхийн хуримтлалын өдөр”-т зориулсан гар зургийн уралдаанд бүтээлээ ирүүлсэн хүүхдүүдээс 50 хүүхдийг азтанаар шалгаруулж, хадгаламжийн эрхийн бичиг гардуулав.
- Нийт 21 аймагт тус аяны хүрээнд санхүүгийн боловсрол олгох сургалт, өдөрлөгүүдийг 3 сарын хугацаанд зохион байгуулж давхардсан тоогоор 500 000 иргэнд хүрч ажиллав.

Харилцагч байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал:

Дэлхийн банк /ДБ/

Иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр батлагдсанаас хойш 12 сарын хугацаанд гаргасан том амжилт бол бага наснаас санхүүгийн боловсролыг эзэмшүүлэх нь их үр дүнтэй маш зөв суурь болж өгдөг бөгөөд Монголбанк Ерөнхий боловсролын сургуулийн 10,11,12 дугаар ангийн хичээлийн хөтөлбөрт шинээр “Бизнес судлал” хичээлийг оруулсан явдал юм. Дэлхийн банкны техникийн туслалцааны хүрээнд Бизнес судлал хичээлийн 11 дүгээр ангийн сурах бичгийг боловсруулах, цахим хуудсыг хэрэгжүүлэх, сургагч багш нарыг бэлтгэх ажил дээр хамтран ажиллав.

Германы Хадгаламжийн банкны ОУ-ын хамтын ажиллагааны сан

ХБНГУ-ын Хадгаламжийн банкны олон улсын сан нь дэлхий дахинд иргэдтэй шууд харьцах банкны ажилтнуудыг чадавхижуулах замаар олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх сургалт хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч орны эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангахыг гол зорилгоо болгодог. Энэхүү зорилгын хүрээнд “Монгол улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийг Монголбанкттай хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн үндсэн зорилго:

1. Монгол улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалтын стандарт тогтоох;
2. Банкны удирдах түвшний ажилтнуудад зориулсан мэргэжлийн семинар зохион байгуулж, явуулах;
3. Монгол Улсад “дэлхийн хуримтлалын өдөр”-ийг танилцуулж, нэвтрүүлэх.

Төслийн хүрээнд 2017 онд хийсэн ажлууд:

- Төслийн хүрээнд нийт 14 мастер сургагч багш нарт зориулан Улаанбаатар хотноо зохион байгууллаа.
- Онол практик хосолсон сургалтын практик хэсгийг төсөлд хамрагдаж буй 14 банкнаас 10 банкны төлөөлөл сургалтанд хамрагдаж менторын эрхээ гардаж авав.
- Онол, практик хослуулсан сургалтыг 2017 онд нийт 41 оролцогчийг 7 модуль хичээлээр бэлтгэв. Үүнд:
 - Модуль 1: Эдийн засгийн суурь ойлголтууд
 - Модуль 2: Хадгаламж
 - Модуль 3: Харилцах данс, төлбөр тооцоо
 - Модуль 4: Зээл
 - Модуль 5: Нягтлан бодох бүртгэлийн суурь ойлголтууд
 - Модуль 6: Харилцагчтай үр дүнтэй харилцах, зөвлөх үр чадвар
 - Модуль 7: Хууль, эрх зүйн суурь ойлголтууд (Банкны тухай хууль г.м)

2016 ЖИЛИЙН ТАЙЛАН

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУЯ-ны хамтарсан тушаалаар баталсан. Энэхүү хөтөлбөрийг дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж буй:

- Сургуулийн насныханд санхүүгийн мэдлэг олгох;
- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
- Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр санхүүгийн мэдлэг олгох.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон нийтийн банк, санхүүгийн системд итгэх итгэлийг дээшлүүлэх, улмаар мөнгөний бодлогын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих эерэг эерэг үр дагавруудыг бий болгох боломжтой.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт
- Хадгаламж
- Зээл
- Хөрөнгө оруулалт
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах арга хэрэгсэл (Даатгал гэх мэт)
- Тэтгэврийн хуримтлал
- Нийгмийн даатгал болон татварын талаарх ойлголтууд
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаарх ойлголтууд

2016 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн болно: Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулагдан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/275 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангид заавал сонгон судлах хичээл болгон гүнзгийрүүлж судлуулахаар шийдвэрлэгдсэн.
- “Бизнес судлал” хичээлийг улсын хэмжээнд нийт 1050 багш, 22,124 сурагчдад заахаар БСШУЯнаас “Бүрэн дунд боловсрол-Бизнес судлалын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга зүй” сургалтыг орон нутгийн 10 бүсэд зохион байгуулсан.
- Ерөнхий боловсролын сургуулиудын 10-р ангийн “Бизнес судлал” сонгон судлах хичээлийн сурах бичгийг боловсруулав.
- Хүүхдүүдэд зориулсан санхүүгийн боловсрол олгох зурагт ном “Анар, Ану 2”, “Хүсэл үү, хэрэгцээ юү?”, “Мөнгө бол мөрөөдөлд хүрэх хэрэгсэл” 2 цувралыг хэвлүүлэн орон нутгийн хүүхэд, сурагчдад түгээв.

- Олон улсын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролын байгууллага /Child&Youth Finance International/-аас “Дэлхий нийтийн санхүүгийн хүртээмжийн шагнал” гардуулах ёслолыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд Монгол Улс 2016 онд Ази - Номхон далайн орнуудын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролыг дэмжигч “Бүсийн аварга” боллоо. Дээрх арга хэмжээнд нийт 500 гаруй байгууллага нэр дэвшиж, 132 орны санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцсон болно.
- Монголбанк Монголын банкны холбоотой хамтран “Дэлхийн мөнгөний долоо хоног” олон улсын арга хэмжээг “Санхүүгийн боловсрол - Миний амьдралд” уриан доор зохион байгуулав.
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос зохион байгуулсан “Монгол Улсын санхүүгийн захын дунд хугацааны хөгжил” форумд оролцож “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг олон нийтэд танилцуулав.
- Ерөнхий боловсролын сургуулийн бага ангиудад (I-Ү анги) санхүүгийн суурь мэдлэг олгоход зориулсан багшийн зөвлөмжийг боловсруулав.
- Ерөнхий боловсролын сургуулийн суурь боловсролын ангиудад (ҮI-IX анги) санхүүгийн суурь мэдлэг олгоход зориулсан багшийн зөвлөмжийг боловсруулав.

Залуучуудад санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд

- Залуу үед санхүүгийн мэдлэг олгох “Хувь хүний санхүү” сэдэвт хичээлийг (1 кредит) бүх их дээд сургуулийн хөтөлбөрт мэргэжил харгалзахгүй тусгуулах зорилгоор сурах бичиг, дасгал ажлын номыг МУИС-ийн Бизнесийн сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, ХААИС-ийн багш нарын бүрэлдэхүүнтэй баг боловсруулав.
- Монголбанк Монгол улсын их сургуулийн Бизнесийн сургуультай хамтран “Хэн сайн санхүүч болох вэ?” сэдэвт уламжлал болсон АХА тэмцээнийг их дээд сургуулиудын оюутнуудын дунд санхүүгийн мэдлэгийг түгээх зорилгоор зохион байгуулав.
- “Банкны ажилтны өдөр”-ийг тохиолдуулан Банк санхүүгийн академитэй хамтран “Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт арилжааны банкуудын харилцагчийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд тулгамдаж байгаа асуудлууд, тэдгээрийн шийдэл, цаашдын хамтын ажиллагааг сайжруулах талаар санал солилцов. Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд
- Монголбанк болон БСШУЯ-ны харъяа Насан түршийн боловсролын төвтэй хамтран насанд хүрэгчдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох хөтөлбөрийн агуулга, 11 сэдэв бүхий гарын авлагыг бэлэн болгов.
- Монголбанкны орон нутгийн салбаруудаараа дамжуулан орон нутгийн иргэд, банк санхүүгийн салбарын ажилтнууд болон сурагчдад санхүүгийн боловсролыг түгээн ажиллаж байна. Цахим хуудас, олон нийтийн хэрэгслээр санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд
- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuugiinbolovсрол.mn цахим хуудсыг Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд боловсруулан, олон нийтэд түгээхэд бэлэн болоод байна.
- Иргэдэд хувийн болон өрхийн санхүүгээ удирдах, хяналттай төсөв зохиоход туслах “Төсөвчин” аппликейшнийг боловсруулав.
- “Монголбанкны мэдээлэл” сар бүрийн товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллуулж байна.

2015 ЖИЛИЙН ТАЙЛАН

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн үндэслэл

Санхүүгийн тогтвортой байдал нь иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий зорилтуудыг хэрхэн хангаж байгаагаар тодорхойлогддог. Санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх асуудал ач холбогдол өндөртэй хэвээр байна. Зах зээл өргөжин тэлж, дэвшилтэт технологи олноор нэвтэрч, банк, санхүүгийн салбар хөгжин, санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ 44 МОНГОЛБАНК ЖИЛИЙН ТАЙЛАН 2015 хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл төрөлжин олширсоор байна. Манай улсад иргэн, өрх гэрийн түвшинд санхүүгийн суурь мэдлэг хангалттай бус байгаагаас санхүүгийн буруу шийдвэр гаргаж эрсдэлд орох, энэ нь санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл үүсгэх эрсдэлтэй байгаа нь энэхүү хөтөлбөрийг өргөн цар хүрээтэй, үр өгөөжтэй хэрэгжүүлэх шаардлагыг зүй ёсоор бий болгож байгаа юм.

Хөтөлбөрийн тухай

Иймээс Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр дэмжин улмаар 10 дугаар сарын 07-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан нь энэхүү хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх эхлэлийг амжилттай тавиад байна. Хөтөлбөрийг боловсруулахад дэлхийн хөгжлийн чиг хандлага, олон улсын түршлага төдийгүй өөрийн орны онцлог байдал, хүн амын санхүүгийн мэдлэгийн түвшинг харгалзан үзэж хөтөлбөрийн тэргүүлэх чиглэл, зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг тодорхойлов. Хөтөлбөрийг сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох, залуу үед санхүүгийн мэдлэг олгох, хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр санхүүгийн мэдлэг олгох дөрвөн тэргүүлэх чиглэлд хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн ач холбогдол

Иргэдийн санхүүгийн мэдлэг сайжрах нь эдийн засгийн бодит өсөлт болон ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэйгөөс гадна хэрэглэгчид, санхүүгийн үйлчилгээний салбар, засгийн газар, төв банк, бусад санхүүгийн зохицуулах үүрэг бүхий байгууллагууд, боловсрол олгогчид, ажил олгогч, ажиллагчид болон сайн дурын байгууллагууд зэрэг олон оролцогч талуудад ашиг тусаа өгөх юм.

Иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр дараах гол үр дүн гарна:

- Иргэдийн мэдлэг дээшилснээр санхүүгийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно;
- Санхүүгийн залилан, мэхлэлээс урьдчилан сэргийлэх явдал нэмэгдэж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна;

- Хувь хүний ажлын бүтээмж нэмэгдэнэ;
- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө;
- Ядуурал, гэмт хэрэг буурна.

Хөтөлбөр дараах 4 чиглэлээр хэрэгжинэ:

1. Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Хувь хүний санхүүгийн суурь ойлголттой болж, төлөвших нас нь хүүхэд наснаас эхэлдэг тул энэ үед санхүүгийн суурь ойлголтуудын талаар үнэн бодитой, зөв мэдээлэл өгөх нь чухал юм. Манай улсын хувьд дунд сургуульд хамрагдалтын түвшин өндөр байдаг тул хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн мэдлэг олгоход бүхэл бүтэн үеийг хамруулж болох гол ач холбогдолтой. Хүүхдүүдийн санхүүгийн боловсрол дээшлэх нь эцэг эхийн санхүүгийн боловсролд эерэг нөлөө үзүүлдэг байна. Одоогийн байдлаар дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт санхүү, эдийн засгийн холбогдолтой сэдвүүд багтаж байгаа боловч харьцангуй макро эдийн засгийн хүрээний асуудлыг хамарсан, өрхийн болон хувийн санхүүг хэрхэн зөв зохистой удирдах талаар бага тусгагдсан. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос хийсэн Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн Иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторингийн сурах бичгүүдийн агуулгад хийсэн судалгаанаас харахад эдийн засгийн ойлголтууд дунд сургуулийн ахлах ангиудын сургалтын хөтөлбөрт багтсан байдаг боловч “Үйлдвэрлэгч ба хэрэглэгч”, “Мөнгө”, “Татвар”, “Эдийн засгийн тогтолцоо”, “Эдийн засаг, зах зээлийн эдийн засгийн тухай ойлголт”, “Эрэлт, нийлүүлэлт”, “Үнэ”, “Өрсөлдөөн”, “Ажилгүйдэл”, “Инфляци” зэрэг цөөн тооны макро эдийн засгийн сэдвүүдийг голлон хамарсан байна.

Авах арга хэмжээ:

- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт бага наснаасаа эхлэн хадгаламжтай болгох, хувийн санхүүгээ удирдаж сурах зэрэг санхүү, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах талаар анхан шатны ойлголт, мэдлэг өгөх агуулгыг багтаах;
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулахад техникийн туслалцаа үзүүлэх болон санхүүжилт олох талаар хамтарч ажиллах;
- Санхүүгийн мэдлэг олгох талаар ерөнхий боловсролын сургуулийн багш нарын чадавхыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, холбогдох ном, гарын авлагыг боловсруулах ажлуудыг хийх;
- Энэ хүрээнд ерөнхий боловсролын 10-р ангийн хичээлийн хөтөлбөрт “Бизнес судлал” хичээл нэмж оруулахаар БСШУ-ны сайдын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/424 тоот тушаалаар хөтөлбөр боловсруулах ажлыг хийж гүйцэтгэхээр болсон. Үүний дагуу “Бизнес судлал” хичээлийн хөтөлбөрийг БСШУЯ болон Монголбанк хариуцан ажиллаж байна.

2. Залуу үед санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Санхүүгийн голлох шийдвэр гаргаж, санхүүгийн зах зээлд идэвхтэй оролцож эхэлдэг үе нь залуу үе буюу 18-25 насныхан байдаг учраас энэхүү насны бүлэгт санхүүгийн мэдлэг олгох нь ач холбогдол өндөртэй байдаг. Манай улсын хувьд нийт хүн амын 30 гаруй хувийг 18-25 насны залуучууд эзэлж байна. 18-25 насныхны хувь ЕБС-ийн хөтөлбөр болон их

сургуулийн сургалтын хөтөлбөрөөс санхүүгийн боловсролын талаар төдийлөн мэдээлэл аваагүйн дээр санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хэрэглээ өргөжиж байгаа энэ үед тус зорилтот бүлэгт анхаарал хандуулах нь зайлшгүй чухал юм. Гэрлэлт, шинэ ажилд орох, шинээр бизнес эрхлэх зэрэг “амьдралын мөчлөгүүд” буюу хүн өөрийн амьдралдаа шууд тусган, шинэ мэдээлэл шингээж чадах үе нь залуу үед голчлон тохиолддог.

Авах арга хэмжээ:

- Оюутан залууст хичээлийн хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн боловсрол олгох, их сургуулийн заавал үзэх суурь хичээлийн хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох сэдвээр тусгах талаар их сургуулиудтай хамтран ажиллах;
- Залууст зориулсан лекц, соёл, олон нийтийн үйл ажиллагааг хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудтай хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулах;
- Шинэ, залуу гэр бүлд санхүүгийн мэдлэг олгох сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан хийх ажлууд багтана.

3. Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Орон нутгийн иргэд хот суурин газартай харьцуулахад алслагдсан, мэдээлэл авах боломж бага байдгаас өөрт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн сонгох, санхүүгийн бусад үйл ажиллагаанд оролцох зэрэгт хүндрэлтэй тулгардаг. Тэтгэврийн насанд хүрэх үедээ зориулж хуримтлал үүсгэх, зохистой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох талаар хөдөө орон нутагт ажиллаж амьдардаг малчид мэдлэг дутмаг байдаг.

Авах арга хэмжээ:

- Орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллагын сүлжээг ашиглан орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Санхүүгийн зах зээлтэй холбогдолтой аливаа хууль эрхзүйн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, санхүүгийн суурь мэдлэг олгох, өөрсдийн эрх ашгийг хамгаалах, тохиромжтой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох зэрэг үр чадварыг нэмэгдүүлэх талаар тусгай албан бус сургалтын хөтөлбөр боловсруулан, орон нутгийн иргэдэд сургалт явуулах сургагч багш бэлтгэж, тусгайлсан сургалт зохион байгуулах;
- Орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллагын сүлжээгээр дамжуулан сургалт хийхэд зориулсан сургалтын гарын авлага, тараах материал боловсруулах;
- Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр үүлзалт зохион байгуулж, тухайн орон нутгийн захиргаа, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах зэрэг ажлууд хийгдэнэ.

4. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэл

Үндэслэл: Сүүлийн жилүүдэд интернет хэрэглэгчид, ухаалаг утас хэрэглэгчдийн тоо сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч байгаа. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн сүлжээгээр мэдээлэл түгээх нь бага зардлаар олон хүнийг хамруулах ач холбогдолтой байдаг.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нэгдсэн цахим хуудас ажиллуулснаар иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах мэдээ, мэдээллээс гадна хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг оролцогч талуудад мэдээлэх, үйл ажиллагаанд хяналт тавих боломж олгоно.

Авах арга хэмжээ:

- Цахим хуудсанд санхүүгийн суурь боловсрол олгох бүхий л төрлийн мэдээ, мэдээллүүдийг байршуулна. Энэ нь иргэдийн санхүүгийн чадамжийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээллүүд байна. Түүнчлэн холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, эдийн засгийн чиглэлийн байгууллагуудаас гарсан төсөл хөтөлбөр, нийтлэл, ярилцлага зэрэг мэдээллүүдийг мөн багтаах юм;
- Холбогдох санхүүгийн тооцоолол хийх програмуудыг боловсруулж, санхүүгийн боловсролыг дэмжих нэгдсэн цахим хуудсанд байрлуулах;
- Цахим хуудсаар дамжуулан иргэдээс тогтмол санал асуулга авч, шаардлагатай мэдээллийн агуулгыг тодорхойлно;
- Телевиз, сонин, сэтгүүл, радио гэсэн уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй санхүүгийн боловсрол олгох зорилготой нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн явуулах талаар хамтран ажиллах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт санхүүгийн суурь мэдлэг олгох агуулгыг багтаах;
- Их, дээд сургуулийн оюутнуудын сургалтын хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох агуулгыг багтаах;
- Иргэдийн хувийн санхүүгийн талаар мэдлэг буюу хяналттай төсөвлөлт хийх, ирээдүйн хэрэгцээнд зориулж нөөц, хуримтлал үүсгэх, урьтаж байх, ирээдүйн тухай тунгаах чадамж дээшилсэн байна;
- Хадгаламжтай иргэдийн тоо нэмэгдсэн байна;
- Хөрөнгийн зах зээлд иргэдээс оруулж буй хөрөнгө оруулалт нэмэгдэнэ;
- Даатгалтай иргэдийн тоо нэмэгдсэн байна;
- Иргэдийн хугацаа хэтэрсэн, найдваргүй өрийн хэмжээ буурна;
- Нэг хүний хэрэглэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний дундаж тоо нэмэгдсэн байна;
- Санхүүгийн бүтээгдэхүүнийг мэдээлэл, мэдлэг дээр үндэслэн зөвөөр сонгох байдал нэмэгдэнэ;
- Санхүүгийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдлэг нэмэгдсэн байна;
- Санхүүгийн зах зээлд оролцогчдын хоорондох мэдээллийн урсгал сайжирсан байна;
- Санхүүгийн залиланд өртсөн иргэдийн тоо буурна гэсэн үр дүнгүүдийг хүлээж байна.

Хөтөлбөрийн үнэлгээ, хяналт

Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ зорилтот хөтөлбөр нь зорилтот бүлэгт хүрч санхүүгийн мэдлэгийн түвшин нэмэгдсэн эсэх болон нөөцийг үр ашигтай зарцуулсан эсэхэд хяналт үнэлгээг төвлөрүүлэн хийх ба ингэснээр хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг цаашид сайжруулах боломж олгох юм. Мөн хөрөнгө оруулагчдад санхүүжилтийг хэрхэн зарцуулсан талаар мэдээллээр хангаж цаашдын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ямар төрлийн үйл ажиллагаанд оруулах талаар шийдвэр гаргахад чухал үүрэгтэй.